



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны _____ сарын _____ өдөр

Дугаар А/58

Аргатай


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар зүйлийн 5.6.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн 61 дүгээр тушаалын 2.1.5, 2.1.6, Засаг даргын зөвлөлийн 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийнхаа үйлдвэрлэгчдийн борлуулалтыг дэмжих, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах, харилцан туршлага солилцох зорилгоор “Баянжаргалан түншлэл-2023” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах арга хэмжээний зардлыг 207900 (Хоёр зуун долоон мянга есөн зуу)-н төгрөгөөр баталсугай.

2. Үзэсгэлэн худалдаанд оролцсон аж ахуйн нэгж, байгууллага, үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг удирдамжийн дагуу шалгаруулж, аж ахуйн нэгж, байгууллага, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг өргөнөөр оролцуулж, үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Р.Отгонбаатар), нарийн бичгийн дарга (Э.Сувд) нарт үүрэг болгосугай.

4. Үзэсгэлэн худалдааны шагналд шаардлагатай 207900 (Хоёр зуун долоон мянга есөн зуу)-н төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Отгонбаатар), нягтлан бодогч (А.Цогзолмаа)-д тус тус зөвшөөрсүгэй.

ДАРГА  О.УУГАНБААТАР